

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХҮН АМЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВ, 2016 ОНД



АРВАЙХЭЭР  
2017 ОН

## **АГУУЛГА**

### **БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ ХАНДЛАГА**

- 1.1 Хүн амын тооны өсөлт, өөрчлөлт
- 1.2 Хот, хөдөөгийн хүн амын харьцаа
- 1.3 Нийт өрхийн тоо, нэг өрхөд ногдох хүн
- 1.4 Хүн амын нас, хүйсийн бүтэц

### **БҮЛЭГ 2. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН**

- 2.1 Төрөлт
- 2.2 Нас баралт
- 2.3 Гэрлэлт, цуцлалт, үрчлэлт

### **БҮЛЭГ 3. ХҮН АМЫН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН**

- 3.1 Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал
- 3.2 Шилжин ирэлт, явалт
- 3.3 Хүн амын цэвэр шилжих хөдөлгөөн


## **ДҮГНЭЛТ**

## БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ ХАНДЛАГА

### 1.1 Хүн амын тооны өсөлт, өөрчлөлт

Өвөрхангай аймгийн хүн амын тоо 2016 оны жилийн эцсийн байдлаар 113.9 мянга болж, өмнөх оныхоос 1.1 мянган хүн буюу 1.0 хувиар өссөн бол 2005 оныхоос 5.7 мян.хүн буюу 5.2 хувиар, 2008 оныхоос 3.5 мян.хүн буюу 3.1 хувиар тус тус өссөн байна. Хүн амын тоо 2005 оноос хойш өссөн хэдий ч өсөлтийн хурд тогтвортой байсангүй. Тухайлбал, хүн амын өсөлтийн хурд 2007-2009 хүртэл өсч байснаа 2010 онд өсөлт саарч, 2012 оноос өсч 2016 онд жилийн дундаж өсөлт 1.0 хувь болсон байна.

ЗУРАГ 1.1 ХҮН АМЫН ДУНДАЖ ӨСӨЛТИЙН ХУВЬ 2005-2016 ОН



Хүн амын өсөлтөд төрөлт, нас баралт, гадаад шилжих хөдөлгөөн гэсэн хүн ам зүйн үндсэн гурван үзүүлэлт шууд нөлөөлдөг.

Сумдын хүн амын өсөлт, бууралтад хүн амын ердийн өсөлтөөс илүү механик өсөлтийн нөлөөлөл их хэвээр байна. Аймгийн төв болон УБ хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал их байгаа нь аймаг, нийслэлийн хүн ам жил ирэх тусам өсөх хандлагыг үүсгэж байна.

Аймгийн нийт хүн амын 49.8 хувь нь эрэгтэйчүүд, 50.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 99.2 байна.

### 1.2 Хот, хөдөөгийн хүн амын харьцаа

2016 оны эцсийн байдлаар аймгийн нийт нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 49.9 хувь буюу 56.9 мянга нь сумын төвд амьдарч байна. Хархорин сумын хүн амын 69.6 хувь нь сумын төвд, Арвайхээр сумын 91.7 хувь нь сумын төвд оршин сууж байна. Харин бусад сумдын хувьд дийлэнх хувь нь хөдөөд амьдарч

байна. 2009-2016 онд аймгийн дунджаар нийт хүн амын 50.0 хувь нь сумын төвд амьдарч байна.

### ХҮСНЭГТ 1.1 ХОТ, ХӨДӨӨГИЙН ХҮН АМЫН ТОО, СУМААР, 2012-2016 он

	2012		2013		2014		2015		2016	
	Сумын төв	Хөдөө	Сумын төв	Хөдөө	Сумын төв	Хөдөө	Сумын төв	Хөдөө	Сумын төв	Хөдөө
Бүгд	57114	53427	61319	50505	65013	47578	63264	49510	16716	16824
Баян - Өндөр	1130	2964	1188	2747	1089	2782	1045	2773	317	842
Бүрд	508	2510	614	2325	854	1989	750	2117	143	704
Бат - Өлзий	2401	4214	4718	2369	4634	2567	3871	3363	818	1375
ББ- Улаан	657	1931	701	1925	1096	1563	1094	1628	262	457
Баянгол	729	3238	712	3143	954	2853	926	2896	201	957
Гучин - Ус	509	1726	940	1243	761	1399	889	1272	144	479
Есөнзүйл	864	2388	859	2290	978	2094	775	2248	229	680
Өлзийт	723	1749	425	2006	625	1866	625	1830	216	524
ЗБ - Улаан	771	2963	745	3206	1225	2780	1242	2703	199	1062
Богд	801	4465	921	4370	1205	4151	1060	4314	247	1200
Нарийнтээл	1093	2560	931	2634	1005	2563	1247	2301	407	618
Сант	676	2673	1136	2339	1194	2500	913	2638	191	841
Тарагт	1178	1923	981	2133	1186	1994	1195	2025	396	691
Төгрөг	837	1940	1150	1562	1020	1650	1158	1493	240	580
Уянга	2964	6086	2861	6145	4230	5104	4044	5385	852	1963
Хайрхандулаан	729	2568	1300	2038	1289	2052	1330	2027	233	873
Хужирт	2964	3786	3379	3234	3442	3094	3182	3448	856	1094
Хархорин	8858	3743	9250	3319	9878	2665	9439	2826	2638	1147
Арвайхээр	28722	0	28508	1477	28348	1912	28479	2223	8127	737

Сүүлийн жилүүдийн хот, хөдөөгийн хүн амын өсөлтийн чиг хандлагыг харахад нийт дүнд эзлэх сумын төвийн хүн амын хувийн жин нэмэгдэж, хөдөөгийн хүн амын хувийн жин буурах төлөвтэй байна. Сумын төвийн өрх өсч байгаа нь аймгийн дотоод шилжих хөдөлгөөний урсгал гол төлөв төв, суурин газар руу чиглэж байгаатай холбоотой юм. Нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт ногдох хүний тоо буюу хүн амын нягтрал 2016 онд 1.8 байна.

Сумаар авч үзвэл Арвайхээр сум нь нийт нутаг дэвсгэрийн дөнгөж 0.3 хувийг эзэлдэг боловч хүн амын нягтралаар хамгийн өндөрт орж байна. 2016 оны байдлаар Арвайхээр сумын нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 177 хүн ногдож байна. Бусад сумдын хүн амын нягтралыг харахад газар нутгийн хэмжээ, хүн амын тооноосоо шалтгаалан харилцан адилгүй, тухайлбал Хархорин, Хужирт, Уянга, Бат-Өлзий зэрэг сумдууд бусдаас өндөр, Төгрөг, Богд, Гучин-Ус зэрэг сумдууд хамгийн бага буюу 1 хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт нэг хүрэхгүй хүн ногдож байна. Энэ нь мөн л хүн амын дотоод шилжих хөдөлгөөний урсгал төврүү чиглэсэн байгааг илэрхийлж байна.

### 1.3 Нийт өрхийн тоо, нэг өрхөд ногдох хүн

2016 онд нийт өрхийн тоо 33.5 мянга болж 2015 оныхоос 0.8 хувиар өссөн байна. Нийт өрхийн 49.8 хувь нь сумын төвд, 50.2 хувь нь хөдөөд амьдарч байна. Хархорин, Арвайхээр зэрэг сумдын сумын төвийн өрх нь хөдөөгийн өрхүүдээс илүү байхад бусад сумдуудын хөдөөгийн өрх нь сумын төвийн өрхүүдээс их байна.

Аймгийн дунджаар нэг өрхөд 3.4 хүн ногдож байгаа бөгөөд нэг өрхөд ногдох хүний тоогоор ББУлаан, Гучин-Ус, Богд, Нарийнтээл, Сант, Арвайхээр сумдууд аймгийн дунджаас өндөр буюу 3.5-3.8 хүн ногдож байгаа юм.

#### ХҮСНЭГТ 1.2 ӨРХИЙН ТОО, ӨРХӨД НОГДОХ ХҮНИЙ ТОО, СУМААР 2012-2016 ОН

	2012	2013	2014	2015	2016	1 өрхийн дундаж ам бүл
Бүгд	<b>32072</b>	<b>32421</b>	<b>33015</b>	<b>33275</b>	<b>33540</b>	<b>3.4</b>
Баян - Өндөр	1219	1180	1169	1166	1159	3.3
Бүрд	830	816	811	832	847	3.4
Бат - Өлзий	2087	2169	2174	2186	2193	3.4
ББ- Улаан	680	686	697	711	719	3.9
Баянгол	1141	1114	1109	1128	1158	3.3
Гучин - Ус	601	589	596	609	623	3.5
Есөнзүйл	918	907	900	914	909	3.4
Өлзийт	764	724	735	736	740	3.3
ЗБ - Улаан	1135	1188	1123	1238	1261	3.2
Богд	1385	1398	1412	1433	1447	3.8
Нарийнтээл	1008	984	1031	1024	1025	3.5
Сант	961	1001	1042	1023	1032	3.5
Тарагт	981	994	1017	1050	1087	3.1
Төгрөг	805	797	793	798	820	3.3
Уянга	2695	2657	2810	2828	2815	3.4
Хайрхандулаан	1014	1032	1052	1068	1106	3.1
Хужирт	1936	1920	1957	1937	1950	3.4
Хархорин	3628	3625	3729	3754	3785	3.3
Арвайхээр	8284	8640	8858	8840	8864	3.5


### 1.4 Хүн амын нас, хүйсийн бүтэц

Хүн амын насны бүтцийг судлах нь одоогийн үйл явцыг үнэлж дүгнэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох бололцоо олгодгоороо ач холбогдолтой юм. Ингэснээрээ хүн амын нас, хүйсийн бүтцийн өөрчлөлтийн чиг хандлагыг харгалзан улс орныхоо нийгэм, эдийн засгийн урт, богино хугацааны бодлого хөтөлбөр боловсруулах үндэслэл болдог.

Хүн амын төрөлт, нас баралтын түвшингээс хамааран тухайн улсын хүн амын насны бүтэц өөрчлөгдөж байдаг. Хүн амын хэдэн хувь нь хүүхэд залуучууд, идэр насныхан, эсвэл хөгшчүүд байгаа нь тухайн цаг үеийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хандлагад нөлөөлдөг. Тухайлбал, үйлдвэр уурхай, барилга, хөдөө аж ахуйн зэрэг салбарт ажиллах хүн хүчний нөөц хэр зэрэг байх, сургууль, эмнэлэг, үйлчилгээний байгууллагын хүчин чадал, байршил ямар байх зэрэг нь хүн амын насны бүтцээс хамаарч зохицуулагддаг. Нөгөө талаар хүн амын төрөлт, нас баралт, шилжих

хөдөлгөөний чиг хандлага ч насны бүтцээс хамааралтай байдаг. Тухайлбал, хүн амын насны бүтэц идэрших хандлагатай болоход (хүн амд хөдөлмөрийн насны хүний эзлэх хувь нэмэгдэх үйл явц) цаашид хөдөлмөрийн насны эрэгтэй, эмэгтэй хүний онцлогийг харгалзан ямар төрлийн ажлын байрыг илүү хэрэгцээтэй болохыг тохируулах шаардлага үүснэ.

ЗУРАГ 1.2 ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ, 2012-2016 ОН



2016 оны нийт хүн амыг насны бүлгээр авч үзвэл 29.9 хувийг 15 хүртэлх насны хүүхэд, 65.8 хувийг 15-64 насны хүн ам, 4.3 хувийг 65 ба түүнээс дээш насны өндөр настнууд эзэлж байна. Ерөнхийдөө хүн амын дунд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь буурч, өндөр настны эзлэх хувь өсч байгааг дээрх графикаас харж болно.

Нийт хүн амд хөдөлмөрийн насныхны эзлэх хувь өндөр байх үеийг “Хүн ам зүйн цонх” гэдэг. Энэ үед улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйл эергээр нөлөөлдөг. Хүн ам зүйн цонх нээгдсэн үед хүүхэд, залуучуудын боловсролын түвшинг дээшлүүлэх, мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх урт удаан хугацааны бодлого хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэн, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ажлын байрыг нэмэгдүүлсэн нөхцөлд ажиллах хүчний нөөц хүрэлцэхүйц байх нөхцөл бүрэлдсэн гэж ойлгож болох юм.

ХҮСНЭГТ 1.3 ХҮН АМЫН ТОО, ХҮН АМ ЗҮЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, СУМААР, 2016 ОН

Сумын нэр	Хүн амын тоо	Хүн ам зүйн ачаалал	Хүйсийн харьцаа
Бүгд	<b>113911</b>	<b>54.4</b>	<b>99.2</b>
Баян - Өндөр	3810	52.9	99.7
Бүрд	2906	54.3	105.1
Бат - Өлзий	7372	55.1	98.5
ББ- Улаан	2773	47.4	99.9
Баянгол	3879	49.9	101.8
Гүчин - Ус	2187	54.9	98.3
Есөнзүйл	3074	57.3	103.4
Өлзийт	2431	50.1	103.4
ЗБ - Улаан	4026	55.9	104.0
Богд	5548	45.7	102.6
Нарийнтээл	3565	50.7	101.1
Сант	3569	49.3	103.0
Тарагт	3323	51.2	106.0
Төгрөг	2735	52.2	101.8


Уянга	9485	48.8	99.3
Хайрхандулаан	3470	54.7	104.9
Хужирт	6660	49.6	102.6
Хархорин	12405	52.5	100.3
Арвайхээр	30693	52.0	93.1

Өвөрхангай аймгийн хүн ам зүйн ачаалал 2016 онд хөдөлмөрийн насны 100 хүнд тэжээлгэгч 54.4 хүн ногдож байна. Амьдралд энэ үзүүлэлт тооцооноос нэлээд илүү байдаг. Тухайлбал, хөдөлмөрийн насанд байгаа үедээ 15-24 насныхан ихэнх нь боловсролоо ахиулах, мэргэжил эзэмшихээр суралцаж, тэжээлгэгч байдаг. Мөн хөдөлмөрийн насанд байгаа боловч жирэмсэн, бага насны хүүхэд, өндөр настанг асран хамгаалагч, хөгжлийн бэрхшээлтэй, ажиллах чадваргүй, эсвэл ажилгүйчүүд гэх мэт тэжээлгэгчдийн тоо өсдөг.

Сумдуудын хүн амын хүйсийн харьцааг харвал Баян-Өндөр, Бат-Өлзий, Баруунбаян-Улаан, Гучин-Ус, Уянга, Арвайхээр зэрэг сумдад 100 эмэгтэйд 93-99 эрэгтэй ногдож байна. Бусад сумдад 100 эмэгтэйд 100-с дээш эрэгтэй ногдож байна.

Хүн амын нас, хүйсийн суваргаас харахад, дунд хэсгээрээ аажмаар өргөсч байгаа нь хүн ам идэрших хандлагатай байгааг харуулж байна. 2016 онд 0-4 насны хүн амын тоо 5-9 болон 10-14 насны хүн амын тооноос их байгаа нь сүүлийн жилүүдэд төрөлтийн тоо нэмэгдэж байгааг харуулж байна. 10-14 насны хүн амын тоо бага байгаа нь 2002-2006 оны төрөлт бага байсныг илэрхийлж байна.

### ЗУРАГ 1.3 ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2016 ОН




2006 оноос эхлэн төрөлт нэмэгдэж эхэлсэн нь суврагаас харагдаж байна. Түүнчлэн 20-29 насны хүн ам харьцангуй их, ерөнхийдөө хөдөлмөрийн насны хүн ам нэмэгдэж хүн ам зүйн цонхны үе үргэлжлэхийг суварга харуулж байна.

## БҮЛЭГ 2. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН

Сүүлийн 10 гаруй жилийн хүн амын цэвэр өсөлт нь Аймгийн хүн амын өсөлтөд нөлөө үзүүлсэн юм. Төрөлтийн ерөнхий коэффициент (ТЕК) 1990 оноос хойш эрчимтэй буурах хандлага ажиглагдаж 2004 онд 20.0, 2005 онд 19.4 болж буурч байсан хэдий ч 2006 оноос өсөх хандлагад хүрч 2016 онд 23.6 болсон байна. Нас баралтын ерөнхий коэффициент 2016 он 5.8 болжээ.

ЗУРАГ 2.1 ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ЦЭВЭР ӨСӨЛТ 1000 ХҮНД НОГДОХООР, 2006-2016



### 2.1 Төрөлт

1990 оноос хойшхи хүн амын төрөлтийн эрчимтэй бууралтанд нийгэм, эдийн засгийн шилжилтийн байдал, 1989 оны сүүлчээр үр хөндөлтийг чөлөөтэй болгосон, эмэгтэйчүүд жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн арга хэрэгслийг хэрэглэж төрөлтөө зохицуулах болсон, гэрлэлтийн нас хойшилсон, цөөхөн ам бүлтэй байх сонирхолтой болсон, эмэгтэйчүүдийн боловсролын түвшин дээшилсэн зэрэг олон хүчин зүйл нөлөөлсөн юм. Гэсэн хэдий ч 2006 оноос эхлэн төрөлтийн түвшин нэмэгдэж эхэлсэн нь Хүүхдийн мөнгө хөтөлбөр, 18 нас хүртэлх хүүхдийн мөнгөн тэтгэмж, Шинэ төрсөн хүүхэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой.

ЗУРАГ 2.2 ТӨРӨЛТИЙН ТОО, сүүлийн 10 жилд хамгийн их бага оноор



Төрөлтийн түвшин 2006-2009 онд нэмэгдэж, 1000 хүнд ногдох төрөлт 2009 онд 26.5 хүрч байснаа 2011 оноос өсөх хандлагаруу орж, 2016 онд 23.6 болж өмнөх оныхоос 0.8 пунктээр буурчээ. Төрсөн хүүхдийн тоо 2016 онд 2675 болж 2015 оныхоос 2.9 хувиар буурсан байна. Аймгийн төрөлтийн тоог сүүлийн 10 жилээр харвал 2009 онд хамгийн өндөр төрөлттэй, 2007 онд хамгийн бага төрөлтийн түвшинтэй байсан байна.



Төрөлтийн тоог сумдаар харвал Арвайхээр сумын төрөлт бусад сумдаас их байгаа нь нийт төрөлтийн түвшний 27.0 хувийг эзэлж байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 71.9 хувь нь хөдөөд буюу сумдад төрсөн байна.

### ХҮСНЭГТ 2.1 ТӨРСӨН ХҮҮХЭД, ХҮЙСЭЭР, СУМААР, 2016 онд

Сумдууд	Төрсөн хүүхэд		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	2675	1384	1291
Баян - Өндөр	12	6	6
Бүрд	28	11	17
Бат - Өлзий	65	32	33
ББ- Улаан	6	3	3
Баянгол	8	4	4
Гүчин - Ус	7	4	3
Есөнзүйл	14	8	6
Өлзийт	10	4	6
ЗБ - Улаан	16	10	6
Богд	54	29	25
Нарийнтээл	17	11	6
Сант	10	6	4
Тарагт	9	6	3
Төгрөг	6	2	4
Уянга	79	44	35
Хайрхандулаан	35	15	20
Хужирт	64	29	35
Хархорин	282	141	141
Арвайхээр	1953	1019	934

### 2.2 Нас баралт

Хүн амын нас баралтын түвшин 2012 онд 1000 хүнд ногдох нас баралт 6.8, 2013 онд 6.2, 2014 онд 6.8 болж өсч байсан бол 2015 онд энэ үзүүлэлт 6.3 болж өмнөх оныхоос 0.5 пунктээр буурчээ. Сүүлийн 10 жилээр нас баралтын түвшинг харьцуулбал 2010 онд хамгийн их буюу 712, хамгийн бага нь 2007 онд 600 байжээ.

ЗУРАГ 2.3 НАС БАРАЛТЫН ТОО , сүүлийн 10 жилд хамгийн их бага оноор



хамгийн өндөр  
2010 онд, 712



хамгийн бага  
2007 онд, 600

Нас барсан хүний тоог сумаар үзвэл Бат-Өлзий, Уянга, Хужирт, Хархорин, Арвайхээр сумдад хамгийн их байна. Мөн нас барсан хүний 35.8 хувь нь аймгийн төвд, 64.2 хувь нь хөдөө сумдад нас баржээ.

### ХҮСНЭГТ 2.2 НАС БАРСАН ХҮН, ХҮЙСЭЭР, СУМААР, 2016 онд

Сумдууд	Нас баралт		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	659	397	262
Баян - Өндөр	25	14	11
Бүрд	16	9	7
Бат - Өлзий	42	24	18
ББ- Улаан	17	8	9
Баянгол	11	8	3
Гүчин - Ус	8	2	6
Есөнзүйл	20	15	5
Өлзийт	5	4	1
ЗБ - Улаан	25	15	10
Богд	46	28	18
Нарийнтээл	14	10	4
Сант	22	13	9
Тарагт	16	9	7
Төгрөг	14	10	4
Уянга	56	39	17
Хайрхандулаан	15	10	5
Хужирт	41	20	21
Хархорин	30	17	13
Арвайхээр	236	142	94

### 2.3 Гэрлэлт, цуцлалт, үрчлэлт


2016 онд нийт 462 хос гэрлэлтээ бүртгүүлж, 55 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 68 хүүхэд үрчлэгджээ. Гэрлэлт өмнөх оныхоос 13.6 хувиар, гэр бүл цуцлалт 24.7 хувиар буурч, хүүхэд үрчлэлт 7.9 хувиар өссөн байна. 1000 хүнд ногдох гэрлэлт 2013 онд 2.3, 2014 онд 3.5, 2015 онд 4.7, 2016 онд 4.1 болж өмнөх оныхоос 0.6 пунктээр буурч, гэр бүл цуцлалт 2013 онд 0.9, 2014, 2015 онд 0.6, 2016 онд 0.5 байна. Гэрлэлтийн тоо нь 2006 онд хамгийн өндөр түвшинд буюу 2450 байжээ.

ЗУРАГ 2.4 ГЭРЛЭЛТИЙН ТОО , сүүлийн 10 жилд хамгийн их бага оноор



1000 хүн амд ногдох гэрлэлт 2004 оноос өсөх хандлагатай болсон ба 2006 оноос эхлэн “Шинэ гэр бүл бологчид” хөтөлбөрийн хүрээнд шинээр гэр бүл бологсдод нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгож эхэлсэнтэй холбоотойгоор гэрлэлт нэмэгдэж 2006 онд 2450 хүрсэн хэдий ч 2007-2013 онуудад тасралтгүй буурч байсан бол 2013 онд өссөн байна.

ЗУРАГ 2.5 1000 ХҮНД НОГДОХ ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТ, 2008-2015 ОН



ЗУРАГ 2.6 ЦУЦЛАЛТЫН ТОО, сүүлийн 10 жилд хамгийн их бага оноор



2015 онд 68 хүүхэд үрчлэгдсэний 55.9 хувь нь 3 хүртэлх насны, 36.8 хувь нь 3-6 насны, 1.5 хувь нь 7-9 насны, 5.9 хувь нь 10 ба түүнээс дээш насны хүүхдүүд байна.

ХҮСНЭГТ 2.3 ХҮҮХЭД ҮРЧЛЭЛТ, НАСНЫ БҮЛГЭЭР, СУМААР 2015 ОН

Сумын нэр	Бүгд	Хүүхдийн насны бүлэг			
		3 хүртэлх настай	3-6 настай	7-9 настай	10, түүнээс дээш настай
Бүгд	68	38	25	1	4
Баян - Өндөр	-	-	-	-	-
Бүрд	1	-	-	1	-
Бат - Өлзий	6	2	4	-	-
ББ- Улаан	-	-	-	-	-
Баянгол	4	3	1	-	-
Гүчин - Ус	-	-	-	-	-
Есөнзүйл	-	-	-	-	-

Өлзийт	-	-	-	-	-
ЗБ - Улаан	1	1	-	-	-
Богд	1	-	1	-	-
Нарийнтээл	4	2	2	-	-
Сант	3	2	1	-	-
Тарагт	4	2	2	-	-
Төгрөг	2	2	-	-	-
Уянга	7	3	3	-	1
Хайрхандулаан	-	-	-	-	-
Хужирт	-	-	-	-	-
Хархорин	6	5	-	-	1
Арвайхээр	29	16	11	-	2

### **БҮЛЭГ 3. ХҮН АМЫН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН**

Хүн амын шилжих хөдөлгөөн нь төрөлт, нас баралтын нэг адил хүн амын өсөлт, өөрчлөлтийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд уугуул нутгийн хүн амын өөрчлөлтийг газар зүйн нэгжүүдээр тодорхойлж, хүн амын хөдөлгөөнийг судалдаг. Хүн амын зарим хөдөлгөөн нь түр зуурын байх буюу уугуул нутаг нь өөрчлөгдөхгүй байх тохиолдлыг шилжих хөдөлгөөнд тооцдоггүй. Иймд шилжих хөдөлгөөн нь тусгайлан тогтоосон засаг захиргааны болон газар зүйн нэгжүүдийн хооронд, түүнчлэн газар нутгийн байршлын /хот, хөдөө/ хувьд явагдах хүн амын суурьшлын өөрчлөлт юм.


Монгол Улсын “Иргэний бүртгэлийн тухай” хуулийн 25 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан журамд “Иргэн байнга оршин сууж байгаа засаг захиргааны нэг нэгжээсээ нөгөөд 180 хоногоос дээш хугацаагаар оршин суухыг бүр мөсөн шилжин суурьших, 180 хоног ба түүнээс доош хугацаагаар оршин суухыг түр шилжин суурьших гэнэ” гэж тодорхойлсон байдаг.

Монгол Улсад хүн амын дотоод шилжих хөдөлгөөний асуудлыг Үндсэн хууль, Иргэний бүртгэлийн тухай, Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай болон бусад холбогдох хууль, түүнчлэн Засгийн газрын 2002 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”, зэрэг хууль тогтоомжоор зохицуулдаг. Дээрх эрх зүйн актуудаар хүн амын шилжих хөдөлгөөнийг зохицуулдаг ч аймагт шилжин суурьшигчдын нэлээд хэсэг нь журмын дагуу шилжиж суурьшаагүй, байнгын оршин суугчийн зөвшөөрөл, албан ёсны бүртгэлгүй хүмүүс байгаа юм.

#### **3.1 Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал**

2016 оны жилийн эцэст 1095 хүн шилжин ирж, 2362 хүн шилжин явсан байна. Нийт шилжин ирсэн хүн амын 366 хүн буюу 33.4 хувь нь аймгийн төвд шилжин ирсэн байна. Мөн Бат-Өлзий суманд 221 хүн, Уянга суманд 45 хүн, Хархорин суманд 138 хүн шилжиж ирсэн байна. Шилжиж явсан хүн амын байдлаас харахад Бат-Өлзий сумаас 246, Хархорин сумаас 389, Арвайхээр сумаас 827, Уянга сумаас 104 хүн явсан нь бусад сумдаас өндөр байна.

ЗУРАГ 3.1 ХҮН АМЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН, 2006-2016 ОН



### 3.2 Шилжин ирэлт, явалт

2016 оны жилийн эцсийн байдлаар нийт шилжин ирэгчдийн 37.6 хувь нь бусад аймгаас, 62.4 хувь нь УБ хотоос шилжин иржээ.


ХҮСНЭГТ 3.1 ШИЛЖИН ИРЭГЧИД, СУМААР, 2006-2016 он

Сумын нэр	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Бүгд	868	576	624	553	698	373	579	793	760	849	1095
Баян - Өндөр	262			18	5	2	7	12	14	29	32
Бүрд	15	14	14	19	30	4	1	24	22	22	43
Бат - Өлзий	31	20	98	27	31	19	9	66	25	30	221
ББ- Улаан	16	11	5	17	3	2		7	7	6	27
Баянгол	1	7	4	3	4	1	2	7	4	23	20
Гүчин - Ус	6	1	8	9	2	1	8	3	8	19	7
Есөнзүйл	17	37	15	12		7	8	20	22	16	17
Өлзийт	13	10	15	7	13	3	12	13	8	17	9
ЗБ - Улаан	2	5	5	15	5	5	3	7	4	17	29
Богд	14	6	4	7	13	6	3	16	19	19	25
Нарийнтээл	8	7	7	20	24	5	9	13	24	20	19
Сант	8	44	15	10	26	2	5	4	6	12	15
Тарагт	3			4	9	11	3	4	6	22	17
Төгрөг	10	5	7	3	4	1	3	1	4	7	26
Уянга	37	62	42	30	31	20	9	13	34	43	45
Хайрхандулаан	5	7	7	15	12	9	2	7	10	21	5
Хужирт	28	51	69	23	66	23	23	36	37	20	34
Хархорин	163	56	111	52	131	39	52	222	153	122	138
Арвайхээр	229	233	198	262	289	213	420	318	353	384	366

2016 оны жилийн эцэст 2362 хүн байнга оршин суудаг засаг захиргааныхаа нэгжээс шилжин явсан байна. Хүн ам зүйн судалгааны шилжих хөдөлгөөнтэй холбоотой чухал үзүүлэлтүүдийн нэг нь шилжин ирэлт, явалтын коэффициент юм. Энэ үзүүлэлт нь 1000 хүнд ногдох шилжин ирэгч, явагчдын тоо юм.

2016 онд 1000 хүн тутмын 10 нь гаднаас шилжин ирсэн байна. Энэ үзүүлэлт нь шилжин явалттай харьцуулахад 2006 оноос хойш өсөлт, бууралт нь харьцангуй хэлбэлзэл бага байсан нь зураг 3.3-аас харагдаж байна.

ЗУРАГ 3.2 ШИЛЖИН ИРЭЛТ, ЯВАЛТЫН КОЭФФИЦИЕНТ, 2006-2016 он



2016 оны эцэст 1000 хүн тутмын 21 нь байнга оршин сууж байсан засаг захиргааны нэгжээсээ шилжин явсан нь 2006 оныхоос 10.0 пунктээр, 2012 оныхоос 3.0 пунктээр нэмэгдэж, 2013 оныхоос 10.0 пунктээр, 2014 оныхоос 7.0 пунктээр, 2015 оноос 2.0 пунктээр тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 3.2 ШИЛЖИН ЯВАГЧИД, СУМААР, 2006-2016 он


Сумын нэр	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Бүгд	1177	2103	1378	1725	2309	3307	1974	3441	3108	2639	2362
Баян - Өндөр	24	-	-	77	83	151	81	199	143	132	143
Бүрд	33	33	92	86	78	78	41	165	173	62	56
Бат - Өлзий	45	66	38	49	90	64	22	82	84	72	246
ББ- Улаан	26	23	26	38	23	40	29	47	41	43	15
Баянгол	3	1	3	6	10	32	61	44	22	80	48
Гүчин - Ус	20	17	21	26	64	18	22	67	30	41	18
Есөнзүйл	55	26	78	67	-	112	72	159	114	115	74
Өлзийт	20	36	35	44	53	85	30	82	72	71	37
ЗБ - Улаан	18	23	48	26	68	45	31	60	54	53	23
Богд	61	40	70	42	77	62	46	71	62	78	54
Нарийнтээл	27	31	31	33	73	40	37	99	89	55	77
Сант	13	105	35	70	105	98	65	98	135	88	67
Тарагт	6	5	12	58	5	52	10	52	28	57	5
Төгрөг	10	10	28	20	11	61	11	41	51	39	32
Уянга	21	38	63	87	107	102	147	183	204	162	104
Хайрхандулаан	25	18	21	34	50	44	41	48	60	49	29
Хужирт	118	123	141	136	161	197	115	231	238	94	118
Хархорин	158	834	38	214	271	359	247	646	526	467	389
Арвайхээр	494	674	598	612	980	1667	866	1067	982	881	827

Аймгийн хэмжээний шилжин явагчдын 35.0 хувь нь Арвайхээр, 16.5 хувь нь Хархорин, 4.4 хувь нь Уянга, 5.0 хувь нь Хужирт сумаас шилжин явагчид эзэлж байна.(Хүснэгт 3.2).

### 3.3 Хүн амын цэвэр шилжих хөдөлгөөн

Шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент (ШХЦК) нь шилжин ирэлт болон шилжин явалтын коэффициентуудын ялгавраар илэрхийлэгдэнэ. Шилжилт хөдөлгөөний ЦК нь 2006 онд -2.8 байсан бол 2013 онд -23.8, 2014 онд -20.9, 2015 онд -15.9, 2016 онд -11.2 болсон байна.

ЗУРАГ 3.3 ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ЦЭВЭР КОЭФФИЦИЕНТ, 2006-2016 онд



Дотоод шилжих хөдөлгөөний хувьд ШХЦК нь 0 гарах ёстой байдаг хэдий ч иргэний бүртгэлийн явцад хугацааны зөрүүтэй байдлаас шалтгаалан энэ үзүүлэлт 0 гарах нь ховор байдаг. Эндээс үзэхэд 2016 онд шилжин явалт нь шилжин ирэлтээс их байгаа нь уугуул нутгаасаа шилжсэн бүртгэл хийлгэсэн иргэд их байгааг харуулж байна.

### ДҮГНЭЛТ

Аймгийн хүн амын тоо 2016 оны жилийн эцсийн байдлаар 113.9 мянга болж, өмнөх оныхоос 1.1 мянган хүн буюу 1.0 хувиар өсчээ. Хүн амын 49.8 хувь нь эрэгтэйчүүд, 50.2 хувь нь эмэгтэйчүүд юм. Хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 99 байна.

Аймгийн хэмжээнд 2016 оны байдлаар 33.5 мянган өрх, түүний 49.8 хувь нь сумын төвд, 50.2 хувь нь хөдөөд байгаа бөгөөд аймгийн дунджаар нэг өрхийн ам бүл 3.4 хүн ногдож байна.

Төрсөн хүүхдийн тоо 2016 онд 2675 болж өмнөх оныхоос 5.6 хувиар буурсан байна. Хүн амын төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охинд ойролцоогоор 107 хөвгүүн ногдож байна. 2016 онд 1000 хүнд ногдох төрөлт 23.6, нас баралт 5.8 болж, өмнөх оныхоос төрөлт 0.8 пунктээр буурч, нас баралт 0.8 пунктээр нэмэгджээ.

2016 онд нийт 462 хос гэрлэлтээ бүртгүүлж, 55 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 68 хүүхэд үрчлэгджээ. Гэрлэлт өмнөх оныхоос 13.6 хувиар, гэр бүл цуцлалт 24.7 хувиар

тус тус буурч, хүүхэд үрчлэлт 7.9 хувиар нэмэгджээ. 1000 хүнд ногдох гэрлэлт 2010 онд огцом буурч, 10.4-өөс 2.7 болсон бол 2013 онд 2.3, 2014 онд 3.5, 2015 онд 4.7, 2016 онд 4.1 болж өмнөх оныхоос 0.6 пунктээр буурч, гэр бүл цуцлалт 2016 онд 0.5 болж, өмнөх оноос 0.1 пунктээр буурсан байна. Гэрлэлтийн тоо нь 2006 онд хамгийн их буюу 2450 болж байсан бөгөөд энэ нь тэр үеийн шинэ гэр бүлд мөнгөн тэтгэмж олгохтой холбоотой тайлбарлаж болох талтай.



Танилцуулгыг нэгтгэж, боловсруулсан:

Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Х. Мөнхцэцэг

Харилцах хаяг: Өвөрхангай аймаг, Арвайхээр сум

Нутгийн удирдлагын ордон, 403 тоот, утас: 70323442

Имэйл: [uvurkhangai@nso.mn](mailto:uvurkhangai@nso.mn) вэб хаяг: <http://uvurkhangai.nso.mn>